



МОНГОЛ УЛСЫН ХҮН АМЫН ХӨГЖИЛ,  
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН  
САЙДЫН ТУШААЛ

2014 оны 06 сарын 06 өдөр

Дугаар #163

Улаанбаатар хот

Журамд нэмэлт, өөрчлөлт  
оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь заалт, “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлийг нөхөн тооцох тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Хүн амын хөгжил, нийгмийн хамгааллын сайдын 2012 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн А/57 дугаар тушаалаар баталсан “Ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэл нөхөн тооцуулах иргэний нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлөх журам”-ын 2.1 дэх хэсэгт дараах агуулга бүхий 2.1.7 дахь заалт нэмсүгэй:

“2.1.7.Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн 1989 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн 198, 199 дүгээр зарлигын дагуу тэтгэврийн насанд хүрээгүй байхдаа өндөр насны тэтгэвэр тогтоолгосон эмэгтэйчүүд,

2. Энэ журмын 2.1.4 дэх заалтад “2.1.6” гэсний дараа “2.1.7” гэж нэмсүгэй.

3.Нийгмийн даатгалын байгууллага нь ажилласан жил, тэтгэврийн даатгалын шимтгэлээ нөхөн тооцуулах хүсэлт гаргасан иргэнийг 2014 оны 6 дугаар сарын 01-нээс 2014 оны 8 дугаар сарын 01-ний өдөр хүртэлх хугацаанд бүртгэн, нийгмийн даатгалын шимтгэлийг нь төлүүлж, баталгаажилтийн хуудсыг 2014 оны 10 дугаар сарын 01-ний дотор олгохоор зохион байгуулж, 2015 оны 1 дүгээр сарын 01-нээс эхлэн тэтгэврийн нэмэгдлийг тооцож олгосугай.

САЙД



С.ЭРДЭНЭ